



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/297

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжих Цэнхэрмандал сумын төвөөс Огзомын цайны газар хүртэлх замын засвар, Хэрлэн суманд Эрчмийн уулзвараас 4-р багийн ахуйн үйлчилгээний төвийн уулзвар хүртэлх явган зам гэрэлтүүлгийн ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд:

Дарга:	Ц.Чогсомжав	аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	И.Басанжав	Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
Гишүүн:	Ц.Бат-Эрдэнэ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга (Ц.Чогсомжав)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ

231011624